Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.8	0.0	-0.8
Авлага	4,295.1	2,924.6	-1,370.5
Урьдчилгаа	29,118.7	20,973.1	-8,145.6
Бараа материал	91,252.2	106,516.3	15,264.1
Үндсэн хөрөнгө	6,094,339.1	5,954,712.2	-139,626.9
Нийт хөрөнгө	6,219,006.0	6,085,126.3	-133,879.7
Өр төлбөр	6,634.6	8,875.3	2,240.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,212,371.3	6,076,250.9	-136,120.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,219,006.0	6,085,126.3	-133,879.7

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй болж 0.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны мөнгөн кассын үлдэгдлийг харилцах дансанд тушаасан байна.

Авлага дансны үлдэгдэл 2,924.6 мянган төгрөг болж 1,370.5 мянган төгрөгөөр буурсан нь 2019 оны жилийн эцэст нэмэлт төсвийн данснаас авлагаар тооцож улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгийг буцааж авснаас шалтгаалжээ.

Нийт авлагаас барагдах боломжгүй, эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 106,516.3 мянган төгрөг болж 15,264.1 мянган төгрөгөөр өсөхөд бэлэн бүтээгдэхүүн дансны үлдэгдэл 14,538.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Энэ нь 2020 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан номын сан, ном судлалын холбогдолтой эрдэм шинжилгээ, онол практикийн өгүүлэл, илтгэлүүд, номзүйн эмхэтгэлүүдийг хэвлүүлж орлогод авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,954,712.2 мянган төгрөг болж 139,626.9 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 85 дугаар тогтоолоор нийтдээ 83,713.9 мянган төгрөгийн хөрөнгийг актлан данснаас хассан болон тайлант үеийн элэгдлийн зардалтай холбоотой байна. Үүнд:

- Ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 26,500.0 мянган төгрөгийн 2 ширхэг автомашиныг /ММС Делика 9776 УБТ, Ниссан Экстрайл 2732 УНМ/ актлан, автотээврийн хэрэгсэл данснаас хассан.
- Машин тоног төхөөрөмж данснаас ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 45 ширхэг 44,398.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг акталж данснаас хассан.
- Тавилга эд хогшил данснаас ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 115 ширхэг 9,766.6 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг акталж хассан.
- Тайлант үеийн элэгдлийн зардал 234,714.0 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 47,661.2 мянган төгрөг, хандиваар ирсэн 40,191.4 мянган төгрөг нийт 87,852.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн ба үүний 79,840.1 мянган төгрөг нь номын фондод нэмэгдсэн байна. Байгууллага өөрийн урсгал төсвөөрөө 4,673.6 мянган төгрөгийн 5 ширхэг принтер, 4 ширхэг скайнер, 1 ширхэг спикер, 3,338.9 мянган төгрөгийн 5 ширхэг тоос сорогч, 1 ширхэг дууны төхөөрөмж худалдаж авсан байна.

Биет бус хөрөнгө 1,769.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хорогдуулга байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 8,875.3 мянган төгрөг болж 2,240.7 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүний орлогын албан татварын өглөг, хувь хүмүүст төлөх номын төлбөр жилийн эцэст төрийн сангийн гүйлгээ хаахаас өмнө гүйлгээгээ хийлгэж амжаагүйгээс шалтгаалж өсчээ.

Урт хугацаат өр төлбөр нь 2008-2032 онд хэрэгжих дулааны үр ашгийн МОН-1548 дамжуулан зээлдүүлэх урт хугацаат зээлийн үндсэн төлбөрийн өрийн үлдэгдэл 4,369.8 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөс залруулан бичсэн үлдэгдэл байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2018, 2019 онуудын 715.3 мянган төгрөгийн өр төлбөр байгаа нь нийт өр төлбөрийн 8.1 хувийг эзэлж байгаа нь иргэдээс худалдан авсан номын өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,076,250.9 мянган төгрөг болж 136,120.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн тайлангаар гарсан алдагдлаас шалтгаалжээ.

Монгол Улсын Үндэсний номын сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 674,462.3 мянган төгрөгөөр буюу 43.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал төсвийн санхүүжилтийн орлого байна. Энэ нь номын сангийн шинэ барилга ашиглалтад орохоор төлөвлөгдөж, санхүүжилтийг өмнөх оноос 717,130.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 677,360.2 мянган төгрөгөөр буюу 39.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна. Эдгээрээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын өсөлт нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосон, Засгийн газрын 382 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн олгож эхэлсэнтэй холбоотой байна. Хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардал нь өмнөх онтой харьцуулахад буурсан нь 2020 онд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан төсвийн зарлагыг бууруулснаас шалтгаалжээ. Урсгал шилжүүлгийн зардлын өсөлт нь 2020 онд тэтгэвэрт гарсан төрийн албан хаагчдад олгосон тэтгэмж, жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 8,333.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга хийсэн нь биет бус хөрөнгөнд бүртгэлтэй “Ганжуур данжуур” ашиглалтын хугацаа тодорхойгүй, ирээдүйд үнэ цэнэ нь өсөх баримтат киног өмнөх жилүүдэд хорогдуулсан байсныг УСНББОУС 31 “Биет бус хөрөнгө” стандартын дагуу залруулснаас шалтгаалсан байна.

Дахин үнэлгээний нэмэгдэл данс 211.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх жилүүдэд дахин үнэлэгдсэн хөрөнгийг данснаас хассантай холбоотой.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,103,079.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,103,079.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,107,383.9 мянган төгрөгөөр бууруулж 1,995,695.2 мянган төгрөгөөр баталсан байна. 2020 оны төсвийн төслийг ийнхүү 4,103,079.1 мянган төгрөгөөр төлөвлөсөн нь номын сангийн шинэ барилга ашиглалтад орохтой холбоотойгоор шинээр 95 орон тоо нэмж авах, тавилга, тоног төхөөрөмж худалдаж авах, халаалт, цахилгаан, цэвэр бохир усны зардал, интернэт, мэдээлэл технологийн зардал, ном худалдаж авах зэрэг зардлуудыг нэмэгдүүлэн төлөвлөж хүргүүлсэнтэй холбоотой байх бөгөөд төсвийг батлахдаа орон тоог 30 хүнээр нэмэгдүүлэн 2019 оны гүйцэтгэлээс 795,426.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ. Үүнд: цалингийн зардлыг 504,726.5 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийг 75,630.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 184,984.7 мянган төгрөгөөр,

урсгал шилжүүлгийн зардал 63,152.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 15,330.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, бусад бүлгийн зардлыг хорогдуулан баталсан байна. Ийнхүү байгууллагаас хүргүүлсэн төсөв 2,107,383.9 мянган төгрөгөөр буурч батлагдсан нь төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах шаардлагатай болохыг харуулж байна.

Covid-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас хийсэн 2020 оны төсвийн тодотголоор Монгол Улсын Үндэсний номын сангийн төсвийг 22,032.5 мянган төгрөгөөр бууруулан 1,938,145.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 109, 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 159, 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 219 тоот дугаар бүхий албан бичгээр дээд шатны төсвийн захирагчид төсөвт зохицуулалт хийх саналыг хүргүүлсэн байна. Үүнд: шинээр ашиглалтад орох барилгын ашиглалтад орох хугацаа цар тахлын нөхцөл байдлын улмаас хойшилсон тул цалин, шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлуудыг бууруулан тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмж болон ном худалдан авах зардал, одоо ашиглаж байгаа барилгын дээвэр, сантехникийн засварын зардлуудыг нэмэгдүүлэхээр тус тус хүргүүлсэн байх бөгөөд зохицуулалт нь 2020 оны 12 дугаар сарын хуваарьт орж батлагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад улирлын үр дүнгийн урамшууллыг олгохоор болж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусгахаар заасан байтал төсвийг төлөвлөж батлахдаа урамшуулалт цалинг төлөвлөөгүй байх тул цаашид зөв ангиллаар төлөвлөж, батлах шаардлагатай байна. Түүнчлэн зарим арга хэмжээний зардлыг хэт бага дүнгээр төлөвлөснөөс шалтгаалан төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэл байна. Тухайлбал: Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж арга хэмжээнд батлагдсан 805.0 мянган төгрөг нь олон улсын номын сангийн холбооны гишүүнчлэлийн зардалд хүрэлцэхгүйгээс өөр зардлаас санхүүжүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх соёл урлаг (71702) хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,938,145.3 мянган төгрөг батлагдсаныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,938,145.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,505,856.9 мянган төгрөгийг зарцуулж, 432,289.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,505,856.9 мянган төгрөг буюу 77.7 хувьтай байгаа нь 2020 оны 7 сард ашиглалтад орох байсан барилга төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ороогүй улмаас барилгатай холбоотой 2020 оны төсөвт нэмж баталсан зардлууд зарцуулаагүй, 432,289.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Монгол Улсын үндэсний номын сан нь 2020 онд нэмэлт төсвийн дансаар “Түвд ном судрыг каталог болон дижитал хэлбэрт оруулах” АСIP (Азийн сонгодгуудыг цахимжуулах

төсөл) олон улсын төслийн санхүүжилт 233,594.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 27,353.2 мянга, нийт 260,947.5 мянган төгрөгийн орлогыг хүлээн авч, 258,097.1 мянган төгрөгийг зарцуулан, үлдэгдэл 2,850.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Монгол Улсын үндэсний номын сан болон АСIP (Азийн сонгодгуудыг цахимжуулах төсөл) хооронд 2018 оны 8 дугаар сард байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг дээр үндэслэн 2 жил гаруй хугацаанд уг төсөл хэрэгжиж 10 ажилтантайгаар түвд номыг бүртгэж, цахимжуулж байна. Түвд номын сан хөмрөг нь нийтдээ 1 сая гаруй гарчиг номтой, төслийн ажилтнууд тогтоосон нормын дагуу каталоги ба цахимжуулах ажлыг хийдэг. Төсөл хэрэгжсэн хугацаанд нийт 42,355 гарчиг ном бүртгэлд оруулсан байна. Мөн 5,297 баринтаг судар бүртгэлд орж гарчгийн дэлгэрэнгүй бүртгэлд орсон. 857,155 хуудас цахим хэлбэрт орсон, 2,834 багц судар зургийн боловсруулалтад орж дууссан байна.

2019 оноос эхлэн соёл, урлагийн байгууллагуудад орлогын төлөвлөгөө батлахгүй болсон. Ингэснээр тухайн байгууллага олсон орлогоо ажилчдын нийгмийн баталгааг хангах, цалин урамшуулал зэрэгт зарцуулах эрхтэй болсон. Монгол Улсын үндэсний номын сан нь 2020 онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 27,353.2 мянган төгрөгийн орлого олсон нь өнгөрсөн онтой харьцуулахад 11,022.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь цар тахлын нөхцөл байдлын улмаас 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрөөс 6 дугаар сарын 21-ний өдрүүдэд соёл урлагийн байгууллагын үзвэр, үйлчилгээг хязгаарласан, 11 дүгээр сарын 11-ний өдрөөс хатуу хөл хорио тогтоож, нийтэд үйлчилгээ үзүүлээгүйтэй холбоотойгоор буурсан байх бөгөөд орлогоос 24,600.0 мянган төгрөгийг Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/35 дугаар тушаалаар ажиллагсдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн зардалд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 89 мэдээлэл, хугацаа болоогүй 4 мэдээлэл, хугацаа хоцроосон 80 мэдээлэл байна. Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 131,678.2 мянган төгрөгийн 9 шийдвэрийг аудитын явцад шилэн дансанд нөхөж оруулсан болно.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15,586.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна.

Аудитаар өгсөн 10,929.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 63.3 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	15,586.2	2	15,586.2			
Зөвлөмж	3	10,929.7	2	10,251.3	1	678.4	36.7
Нийт дүн	5	26,515.9	4	25,837.5	1	678.4	36.7

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 825,109.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 813,955.2 мянган төгрөгийн алдааг залруулж, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансанд оруулбал зохих мэдээллийг мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн, түүнчлэн худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж шууд худалдан авалт хийсэн 11,154.5 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, батлан мөрдөх, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох талаар 2 зөвлөмжийг өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах 813,955.2 мянган төгрөгийн залруулгыг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон шилэн дансны мэдээлэлд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсвийн жилийн эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн 432,288.4 мянган төгрөгийг төсвийн тохируулга хийгээгүй төсвийн гүйцэтгэлийг буруу тайлагнасныг залруулав.
2. Машин тоног төхөөрөмж дансанд 50.0 мянган төгрөгийн ном, бичиг хэргийн материал болон аж ахуйн материал дансанд ашиглалтад тавьж олгосон 5,266.9 мянган төгрөгийн хангамжийн материалыг бүртгэсэн байх тул хөрөнгийн ангиллыг залруулан бүртгэв.
3. Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй ашиглалтын хугацаа тодорхойгүй, цаашид үнэ цэнэ нь өсөх “Ганжуур данжуур” баримтат кинонд 8,333.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсныг өмнөх үеийн үр дүнд залруулав.
4. Үндэсний номын сангийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн А/34-р тушаалаар акталсан 2,906.1 мянган төгрөгийн бараа материалыг бараа материал акталсны зардал 210408 тоот дансанд бичээгүй, бараа материалын холбогдох зардлуудыг нэмэгдүүлэн бичсэнийг залруулав.
5. Үндэсний номын сангаас 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 15 тоот албан бичгээр аудит хийлгэхээр ирүүлсэн тайлангийн бүрдлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1 заалт, Төсвийн тухай хуулийн 54.4, 54.5 заалтуудад тус тус заасан бүрэлдэхүүнээр бэлтгэж ирүүлсэн эсэхийг тулган шалгахад санхүүгийн тайлангийн тодруулгыг 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан загвараар бэлтгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан бүрэлдэхүүнээр гаргаж ирүүлээгүй байсныг аудитын явцад залруулан тайлан, тодруулгыг бэлтгэж, ирүүлсэн.
6. Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг шалгаж үзэхэд 68 ш тавилга эд хогшилд хамаарах 10,486.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу байгуулсан байсныг аудитын үед нөхөн байгуулж, залруулга хийлээ.
7. 2008-2032 онд хэрэгжих дулааны үр ашгийн МОН-1548 дамжуулан зээлдүүлэх урт хугацаат зээлийн үндсэн төлбөрийн өрийн үлдэгдэл 4,369.8 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэж, тайлагнасныг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэж, залруулав.
8. Бусад хангамжийн материал дансанд 800.0 мянган төгрөгийн шатахууныг орлого авч, 630.0 мянган төгрөгийг зарцуулан 170.0 мянган төгрөгийн үлдэгдлийг бүртгэснийг аудитын явцад шатах тослох материалын данс уруу залруулав.
9. Мөнгөн хөрөнгийн тодруулгын нэмэгдсэн болон хасагдсан гүйлгээний дүн төсөвт байгууллагын өөрийн орлогын 20,346.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байсныг залруулсан. Үндсэн хөрөнгийн тодруулгын худалдан авсан хөрөнгийн дүн мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө худалдаж авсан дүнгээс 2,169.0 мянган төгрөгөөр зөрснийг залруулсан.
10. Цалингийн цэснээс олгохоор тооцоолсон цалинг үндсэн цалин, нэмэгдэл цалин, хоол унааны хөнгөлөлт, урамшуулал гэсэн ангиллаар нь түүвэрлэн үр дүнгийн тайлангийн үзүүлэлттэй тулгахад 140,264.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг нэмэгдэл цалингийн дүнд оруулан тайлагнасан байсныг залруулав.

11. Нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоогүй боловч төсвийн ил тод байдалтай холбоотой, олон нийтэд зайлшгүй мэдээлэх шилэн дансны мэдээллийг аудитын явцад нөхөн оруулж 187,305.3 мянган төгрөгийн алдааг залруулсан болно. Үүнд:

- төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 131,678.2 мянган төгрөгийн 9 шийдвэр
- худалдан авах ажиллагааны 2020 оны тайлан
- нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл
- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг
- цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 11,154.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 11,154.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”*, 6.4.4-т *“таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;”*, 6.4.8-д *“бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;”* гэж заасныг тус тус зөрчсөн нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. 2020 онд багаж, техник, хэрэгслийн зардалд 30,000.0 мянган төгрөг батлагдсан байх бөгөөд харьцуулалтын аргаар цахим тендер зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулаагүй 11,154.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т *“Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”*, 33 дугаар зүйлийн 33.2.1-д *“үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх;”* гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2 төрлийн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх

Анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Монгол Улсын Үндэсний номын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт, соёлын биет өвд бүртгэлтэй хөрөнгийн бүртгэлийн асуудлыг нарийвчлан шалгах шаардлагатай.

Төсвийн төлөвлөлтийг гол анхаарах асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Монгол Улсын үндэсний номын сан нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа, онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нээж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэж заасныг мөрдөөгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Эрсдэл: УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт хэрэгжихгүй байх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС 3 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т заасны дагуу өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж буй 205 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1 заалт “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй, “толилуулга ба тодруулга”, “үнэлгээ” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.
- 2.2. Эрсдэл: Хөрөнгийн өртөг бодит үнэ цэнээрээ илэрхийлэгдэхгүй байх, хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах, төрийн өмчийг үнэгүйдүүлэх, улмаар хөрөнгийг ашиглах, завших, хямд үнээр данснаас хасах эрсдэлтэй.
- 2.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС 21 Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн хэрэгжилтийг хангаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож, бүртгэх.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: Монгол Улсын Үндэсний номын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	САГ-2021/68/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Монгол Улсын Үндэсний номын сан	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагаас шилэн дансанд мэдээлэх 173 мэдээллээс 80 мэдээллийг хугацаа хоцроосон.	-	Албан шаардлагыг хүргүүлэх	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Ичин хорлоо Э.Энхзул
2	2020 онд багаж, техник, хэрэгслийн зардалд 30,000.0 мянган төгрөг батлагдсан байх бөгөөд харьцуулалтын аргаар цахим тендер зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулаагүй 11,154.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авсан байна.	11,154.5	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Ичин хорлоо Э.Энхзул
3	Монгол Улсын үндэсний номын сан нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа, онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөөгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Ичин хорлоо Э.Энхзул
4	Үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж буй 205 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Ичин хорлоо Э.Энхзул
ДҮН		11,154.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 05

№ 144/А0170063

Улаанбаатар хот

САГ-2021/68/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын үндэсний номын сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд багаж, техник, хэрэгслийн зардалд 30,000,0 /гучин сая / мянган төгрөг батлагдсан бөгөөд харьцуулалтын аргаар цахим тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалгүйгээр 11,154.5 /арван нэгэн сая нэг зуун тавин дөрвөн/ мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 33 дугаар зүйлийн 33.2.1-д "үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоо, ахлах нягтлан бодогч Э.Энхзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Б.МЯДАГМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10\Bichig_Kherem\Alban Shaardlaga\2021\0225auditin 2-R Gazar 159.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 46/А070069

Улаанбаатар хот

СБТ- 2021/68/СТА-ТЦЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Үндэсний номын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 173 мэдээлэл байршуулахаас 80 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр хаяг," 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоо, ахлах нягтлан бодогч Э.Энхзулд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ч.ДАШДАВАА

Б.МЯДАГМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

